



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 16 өдөр

Дугаар А/253

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтыг /XV.1.1.76/, Зам тээврийн хөгжлийн сайдын 2024 оны 01 дүгээр сарын 12 ны А/06 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан “Сумын төвийн хатуу хучилттай авто замын эхлэх, 0.8 км /Булган Хутаг-Өндөр сум/” ажлын гүйцэтгэгчээр Орхон аймгийн “Энх-Алтаргана” ХХК-ийг шалгаруулж 530,388,823 (Таван зуун гучин сая гурван зуун наян найман мянга найман зуун хорин гурав) төгрөгөөр гэрээ байгуулж, ажлын гүйцэтгэлд холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Ү.Бямбасүрэн)-д үүрэг болгосугай.

2. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Энх-Алтаргана” ХХК-ийн захирал (А.Энхжаргал)-д даалгасугай.

3. Дээрх ажлын санхүүжилтийг хууль, журам, гэрээний дагуу тооцон олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  БАРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2024 оны
дүгээр сарын 1-ний өдрийн А/253 дугаар
захирамжийн хавсралт



Д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.05 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Д.Батцогт
2	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь.	Д.Батцогт
3	Гүйцэтгэлийн баталгаа	3 хувь	Ү.Бямбасүрэн
4	Зөвлөх үйлчилгээний зардал	19,776,436	Ү.Бямбасүрэн
5	Захиалагчийн хяналтын зардал	1,977,644	Ү.Бямбасүрэн
6	Магадалшгүй ажил	9,062,896	Ү.Бямбасүрэн
7	Ажил гүйцэтгэх хугацаа	60 хоног	Ү.Бямбасүрэн
8	Нормчлолын сан	1,812,579	Ү.Бямбасүрэн
9	Зураг төсөл	3,300,000	Ү.Бямбасүрэн